



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн сахилгын хорооны даргын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/32/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Долгорсүрэн

Утас: 261740 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Амарсанаа

Утас: 261740 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn

Аудитор: Ж.Мөнхтуул

Утас: 261740 Цахим хаяг: munkhtuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....
 - 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
 - 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....
 - 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
 - 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан
 - 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
 - 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
3. Аудитын илрүүлэлт
- 3.1 Албан шаардлага
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШСХ	Шүүхийн сахилгын хороо



ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ
ДАРГА Ц.ДАВХАРБАЯР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1133
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн сахилгын хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Шүүхийн сахилгын хорооны 2023-2027 оны стратеги төлөвлөгөөг баталж, алсын хараа, эрхэм зорилгыг тодорхойлсон байна.

Мөн хорооны үйл ажиллагааг цахимжуулах ажлын хүрээнд “Сахилгын хэргийн бүртгэл хяналтын систем”-ийг нэвтрүүлснээр өргөдөл, мэдээлэл бүртгэхээс гадна гомдол, эсэргүүцэл, санал, хүсэлтийг шийдвэрлэх даргалагч, бүрэлдэхүүн, илтгэгч гишүүнийг томилох ажиллагааг системээс санамсаргүй тохиолдлоор, цахимаар хуваарилах боломжтой болсноор гишүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлж, шүүгчийн сахилгын зөрчлийн талаарх лавлагаа, мэдээллийг түргэн шуурхай гаргах давуу талыг бий болгосон байна.

Аудитын гол асуудал

Шүүхийн сахилгын хороо байгуулагдсанаас хойш өөрийн ажлын байргүй, Засгийн газрын XI дүгээр байранд 588.7м2 талбайг түрээслэн үйл ажиллагаагаа явуулдаг байсан

Z:\Yawsan_Bichigt\2024\0425 SNAG-13.Docx

0001030754

бөгөөд тайланд онд Улсын дээд шүүхийн байрны өргөтгөлийн хэсэгт үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайланд онд үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор барилгын засвар, үйлчилгээний ажлыг гүйцэтгэн Шүүхийн сахилгын хорооны зөвлөгөөний болон сахилгын хэрэг хянан шийдвэрлэх хуралдааны танхимыг тохижуулах, сахилгын хэргийн оролцогчийн аюулгүй, ил тод байдал, бодит оролцоог хангах үүднээс хуралдааны танхимыг цахимжуулан тоног төхөөрөмж суурилуулах ажлыг гүйцэтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Шүүхийн сахилгын хороо "Шүүхийн ёс зүй, сахилга хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, ил тод нээлттэй байдлыг хангах" зорилгыг дэвшүүлэн 7 зорилтын хүрээнд 90 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 95.0 хувийн хэрэгжилттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАГДЖАВ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	395,871.3	825,614.7
33	АВЛАГА	-	5,146.5
34	УРЬДЧИЛГАА	332,750.0	709,195.6
35	БАРАА МАТЕРИАЛ	63,121.2	111,272.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,130,779.8	1,121,495.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,130,779.8	1,121,495.9
39200	Биет хөрөнгө	1,118,824.8	1,112,384.9
39300	Биет бус хөрөнгө	11,955.0	9,111.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,526,651.1	1,947,110.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	181.0	5,990.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	181.0	5,990.1
41300	Өглөг	181.0	5,990.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,526,470.1	1,941,120.6
51	Засгийн газрын хувь оролцоо	1,526,470.1	1,941,120.6
51200	Хуримтлагдсан үр дүн	1,526,470.1	1,941,120.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,526,651.1	1,947,110.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,676,739.5	3,505,158.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	211,110.4	2,139.0
120	Нийтлэг татварын бус орлого	211,110.4	2,139.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,465,629.1	3,503,019.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,151,174.6	3,090,508.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,151,174.6	3,090,508.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,030,373.3	2,904,384.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,372,680.3	1,836,729.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	163,621.8	231,355.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,650.1	137,998.2
2104	Хангамж, бараа материалын зардал	135,156.1	207,185.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,148.6	37,425.3
2107	Томилолт, зочны зардал	50,553.0	61,999.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,395.8	77,651.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,167.6	314,038.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	120,801.3	186,123.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,525,564.9	414,650.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,525,564.9	414,650.4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,465,629.1	3,503,019.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,465,629.1	3,503,019.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,418,608.6	3,246,240.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,418,608.6	3,246,240.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,297,807.3	3,060,116.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,371,775.1	1,836,938.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	163,621.8	231,147.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,650.1	137,998.2
2104	Хангамж, бараа материалын зардал	142,806.7	197,771.4
2105	Нормативт зардал	1,680.8	4,127.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	376,443.0	390,067.9
2107	Томилолт, зочны зардал	51,085.7	61,999.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,224.2	151,665.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,520.0	48,400.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	120,801.3	186,123.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,124.0	69,974.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,677.2	116,149.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,047,020.5	256,779.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,047,020.5	256,779.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,047,020.5	256,779.3
2200	Дотоод эх үүсвэрээр	1,047,020.5	256,779.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,047,020.5)	(256,779.3)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	905.2	905.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	905.2	905.2
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,525,564.9	1,525,564.9
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,526,470.1	1,526,470.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,526,470.1	1,526,470.1
19	Тайлант үеийн үр дүн	-	-	414,650.4	414,650.4
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	1,941,120.6	1,941,120.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

					/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,503,050,500.00	3,386,869,810.46	116,180,689.54	96.7	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,503,050,500.00	3,386,869,810.46	116,180,689.54	96.7	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,433,045,600.00	3,316,895,810.46	116,149,789.54	96.6	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,944,835,900.00	1,836,938,558.60	107,897,341.40	94.5	
210101	Үндсэн цалин	1,113,260,400.00	1,139,345,374.10	(26,084,974.10)	102.3	
210102	Нэмэгдэл	522,433,900.00	385,867,986.08	136,565,913.92	73.9	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	179,336,000.00	179,013,047.75	322,952.25	99.8	
210104	Урамшуулал	129,805,600.00	132,712,150.67	(2,906,550.67)	102.2	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	239,136,100.00	231,147,040.99	7,989,059.01	96.7	
210201	Тэтгэврийн даатгал	162,612,500.00	157,487,538.01	5,124,961.99	96.8	
210202	Тэтгэмжийн даатгал	19,130,900.00	18,526,592.30	604,307.70	96.8	
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,304,800.00	14,753,416.73	551,383.27	96.4	
210204	Ажилгүйдлийн даатгал	3,826,200.00	3,670,863.18	155,336.82	95.9	
210205	Эрүүл мэндийн даатгал	38,261,700.00	36,708,630.77	1,553,069.23	95.9	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,219,600.00	137,998,159.00	221,441.00	99.8	
210304	Байрны түрээс	138,219,600.00	137,998,159.00	221,441.00	99.8	
2104	Хангамж, бараа материалын зардал	198,194,300.00	198,176,438.39	17,861.61	100.0	
210401	Бичиг хэрэг	37,720,900.00	37,720,900.00	-	100.0	
210402	Тээвэр, шатахуун	51,573,400.00	51,560,339.00	13,061.00	100.0	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	36,768,000.00	36,763,438.39	4,561.61	100.0	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	132,000.00	132,000.00	-	100.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	72,000,000.00	71,999,761.00	239.00	100.0	
2105	Нормативт зардал	4,127,800.00	4,127,800.00	-	100.0	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,127,800.00	4,127,800.00	-	100.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	646,442,200.00	646,442,200.00	-	100.0	
210601	Багаж, техник, хэрэгсэл	279,442,200.00	279,442,200.00	-	100.0	
210604	Урсгал засвар	367,000,000.00	367,000,000.00	-	100.0	
2107	Томилолт, зочны зардал	62,000,000.00	61,999,902.00	98.00	100.0	
210702	Дотоод албан томилолт	62,000,000.00	61,999,902.00	98.00	100.0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	151,689,700.00	151,665,711.48	23,988.52	100.0	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	96,418,600.00	96,418,600.00	-	100.0	

210803	Даатгалын үйлчилгээ	33,223,100.00	33,213,103.48	9,996.52	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	395,000.00	385,008.00	9,992.00	97.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	349,000.00	349,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,304,000.00	21,300,000.00	4,000.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,400,000.00	48,400,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	48,400,000.00	48,400,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,004,900.00	69,974,000.00	30,900.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,004,900.00	69,974,000.00	30,900.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	70,004,900.00	69,974,000.00	30,900.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,503,050,500.00	3,386,869,810.46	116,180,689.54	96.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,503,050,500.00	3,386,869,810.46	116,180,689.54	96.7
310001	Улсын төсвөөс санхүүжих	3,503,050,500.00	3,386,869,810.46	116,180,689.54	96.7
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	111	107	4	96.4
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	55	53	2	96.4
620001	Удирдах ажилтан	12	12	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	24	22	2	91.7
620003	Үйлчлэх ажилтан	19	19	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	55	53	2	96.4
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	27	25	2	92.6
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19	19	-	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5	5	-	100.0
650012	Шүүгч, прокурор	4	4	-	100.0

3.Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 40.4 сая төгрөгийн зөрчлийг¹ илрүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 40.4 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6.0 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй дүгнэлт” өглөө.

Зөвлөмж

1. Худалдан авалттай холбоотой

Илрүүлэлт 1. Худалдан авах ажиллагааны нэмэлт төлөвлөгөөг боловсруулахдаа босго үнийн хязгаараас давсан 118.0 сая төгрөгийн тавилгыг гэрээ шууд байгуулах аргаар худалдан авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр урсгал төсвөөс 14 аж ахуй нэгж, байгууллагаас 117.0 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг худалдан авсан байна. Үүнээс: Багцалж тендер зарлах боломжтой 39.7 сая төгрөгийн тавилгыг 2 аж ахуй нэгж, байгууллагаас гэрээ шууд байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт өртөг болон шинж чанарыг харгалзан үзэж, хууль, журамд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, баталсан төсвийг хяналттай, үр ашигтай зарцуулах зөвлөмж өгөв.

2. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт 2. Урсгал засварын зардлаас 0.6 сая төгрөгийн аяны хэрэгсэл буюу бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", Сангийн Сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын 210604 "байгууллага өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга байгууламж, тээврийн хэрэгсэлд урсгал шинжтэй засвар хийх зориулалтаар бэлтгэсэн материал, сэлбэг, засвар үйлчилгээний хөлс байна" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баталсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай зарцуулж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4.Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Худалдан авах ажиллагааны нэмэлт төлөвлөгөөг боловсруулахдаа босго үнийн хязгаараас давсан 118.0 сая төгрөгийн тавилгыг гэрээ шууд байгуулах аргаар худалдан авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр урсгал төсвөөс 14 аж ахуй нэгж, байгууллагаас 117.0 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг худалдан авсан байна. Үүнээс: Багцалж тендер зарлах боломжтой 39.7 сая төгрөгийн тавилгыг 2 аж ахуй нэгж, байгууллагаас гэрээ шууд байгуулан худалдан авсан байна.	1	39.8					1	39.8				
Урсгал засварын зардлаас 0.6 сая төгрөгийн аяны хэрэгсэл буюу бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл худалдан авсан байна.	1	0.6					1	0.6				
Дүн	2	40.4					2	40.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Тайлант онд шилэн дансны мэдээллийн системд 5 саяас дээш үнийн дүн бүхий зарлагын нийт 72.2 сая төгрөгийн 9 гүйлгээг байршуулаагүй, 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан болон 2024 оны төсвийн саналыг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	72.2			1	72.2		
Дүн	1	72.2			1	72.2		
Бусад хууль тогтоомжтой холбоотой								
Дээд шүүхийн барилгын урсгал засварын сүүлийн блокийн ажил эхлээгүй байхад Ажлын хэсгийн хуралдааны шийдвэрээр Рэд Лайн ХХК-д 78.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.	1	78.4					1	78.4
Хорооны эзэмшилд бүртгэлтэй 9 автотээврийн хэрэгсэлд бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй байна.	1	-					1	-
Дүн	2	78.4				-	2	78.4
Нийт дүн	3	150.6			1	72.2	2	78.4